



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЖАРГАЛТХААН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 5/02

Жаргалтхаан

**Н.Мөнхжаргалыг түр ажиллуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүжгийн багш Н.Соёлмаагийн хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусч ажилдаа эргэн орох хүртэл хугацаанд Н.Мөнхжаргалыг 2025 оны 01 дугаар сарын 08 ний өдрөөс эхлэн бүжгийн багшаар түр ажиллуулсугай.

2. Бүжгийн багш Н.Мөнхжаргалын цалинг ТҮСБ-3 зэрэглэлийн 1.414.000 (сая дөрвөн зуун арван дөрвөн мянган) төгрөгөөр, орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцож цалинжуулахыг нягтлан бодогч (Э.Эрдэнэхүү) -д зөвшөөрсүгэй.

3. Н.Мөнхжаргалын ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ц.Болд-эрдэнэ (Дуу хөгжмийн багш)

Гишүүд: Н.Энхтунгалаг (Номын санч)

Л.Өсөхгэрэл (Өвийн ажилтан)

4. Бүжгийн багшийн албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган хэрэгжүүлж, хариуцсан ажлаа чанартай гүйцэтгэн, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг чанд мөрдөж ажиллахыг Бүжгийн багш Н.Мөнхжаргал-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.АРИУНГЭРЭЛ